



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/24

Мөрөн сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлын тов тогтоох тухай

Монгол улсын Засаг захирга нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 61 дүгээр зүйлийн, 61.1.2, 61.7, 61.9 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, Могойн голын ХК-ний дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Могойн гол хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 15 цагт Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар баг аймгийн Засаг даргын Тамгын газрын "А" байр 3 дугаар давхар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Иргэний Танхим" байранд зохион байгуулахаар товлоусугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.

2.1. Могойн гол ХК-ийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, зардал батлах

2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 1 дүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтын хуудсыг 2 дугаар хавсралтаар, саналын хуудсыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах өдрийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдөр, дахин мэдээллэх өдрийг 06 дугаар сарын 28-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 06 дугаар сарын 30-ны өдрөөр, эцнээ санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээн авах эцсийн өдрийг 2026 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөр тус тус тасалбар болгон тогтоосугай.

5. Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд: Зохион байгуулах комиссын дарга:

Г.Гандэлгэр-Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гишүүдэд: Ц.Бэхбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Р.Машбат-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

6712010078

Ц.Баттогтох-Компаний гүйцэтгэх захирал

Э.Даваачулуун-ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч

6.Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Г.Гандэлгэрийг томилсугай.

7.Хурлын тооллогын комиссын дарга; гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Тооллогын комиссын дарга: Г.Өнөржаргал Могойн гол ХК-ийн хүнийн нөөц хариуцсан ажилтан

Б.Будсүрэн- аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажилтан

Бат-Очир- Могойн гол хувьцаат компанийн жижиг хувьцаа эзэмшигч

7.Компанийн тухай хууль болон дүрмийн дагуу хурлыг зохион байгуулахыг комиссын дарга (Г.Гандэлгэр), тооллогын комиссын дарга (Г.Өнөржаргал) нарт даалгасугай.

8.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2026 оны оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/23 захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ПҮРЭВДОРЖ